**БАЯНХОНГОР АЙМГИЙН**
**БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 30 өдөр　　　　Дугаар 07/42　　　　Булган

Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн
дээд, доод хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 52 дугаар зүйлийн 52.1.2, 52.1.4, 52.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Хоршоо хөгжүүлэх сангаас олгох зээлийн доод хэмжээг 1,000.0 (нэг сая) төгрөгөөр, зээлийн дээд хэмжээг 80,000.0 (наян сая) хүртэл төгрөгөөр тогтоосугай.

2. Төсөл шалгаруулан зээл олгоход энэхүү тогтоолыг баримтлан ажиллахыг хорооны дарга, гишүүдэд үүрэг даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Э.Бүжмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/15 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА　　　　Ж.ДОЛООН-ОД

0721015

D:\Togtool\togtool 2022.docx